

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 03 дугаар сарын 04-ны өдөр

дугаар № 01

Дархан-Уул аймаг

“Дархан нэхий ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Дархан нэхий ХК-ийн охин компани болох Гранд як ХХК-ын 2001 тоот хурлын танхимд 2023 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 12⁰⁰ цагт нийт 905.790.188 ширхэг хувьцаатай, хувьцаа эзэмшигчид оролцсоноор 82.0 %-ийн ирцтэйгээр хурлыг хийлээ.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Э. Батсайхан	326 903 000 ш	7. Х. Золжаргал	17 213 000 ш
2. Р. Сүмбэнхүү	301 008 000 ш	8. “ННТТ” ХХК	205 704 000 ш
3. Б. Дагвацэрмаа	29 087 000 ш	9. Б. Чанцал	2 341 000 ш
4. Б. Гэрэлмаа	7 800 000 ш	10. С. Хулан	2 120 188 ш
5. С. Норжмаа	2 811 000 ш		
6. Д. Батжаргал	10 803 000 ш		

Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс томилсон тухай шийдвэрийг ТУЗ-ийн нарын бичгийн дарга Х. Нарантуяа танилцууллаа.

Б. Орхончимэг Тооллогын комиссын дарга

-Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын бүртгэлийг хуулийн дагуу хийж, ирцийг мэдээлж, санал өгөх зааврыг танилцуулав. Тэрээр хувьцаа эзэмшигчид энэхүү хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №1-ээр, ТУЗ-ийн гишүүдийг сонгож санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №2-оор тус тус бичгээр өгнө. Харин ТУЗ-ийн гишүүнийг сонгох санал өгөхдөө Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 09 сарын 09-ны өдрийн 880 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “Санал хураах кумулятив арга хэрэглэх журам”-ыг баримтлан санал өгнө гээд уг журмыг тайлбарлан танилцууллаа.

Хурлын дарга Х. Золжаргал:

-Хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд хүрэлцэн ирсэн Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ талархал илэрхийлж, мэндчилье.
-Тооллогын комиссын мэдээллээр хуралд оролцох Хувьцаа эзэмшигчдийн ирц 78,5%-тай байгаа тул хурлын ирцийг хангалттай гэж үзэж хурлаа эхлүүлж байна. Та бүхэндээ хурлын дэгийг танилцуулья.
-Хурлын дэгтэй холбоотой асуудалд санал байна уу.
-Хурал оролцогч та бүгдээс өөр санал байхгүй бол хурлын дэг ёсоор хэлэлцэх асуудлыг, асуудал тус бүрээр хэлэлцсэний эцэст хувьцаа эзэмшигчид батлагдсан саналын хуудсаар саналаа өгч, тооллогын комисс эцсийн шийдвэрийг гарган дүнг танилцуулна. Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж /Өнөөдрийн хурлаар 7 асуудлыг хэлэлцэнэ. Одоо хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулья.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг танилцуулах
3. Дархан нэхий ХК-ийн дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэж батлах
4. ТУЗ-ийн гишүүнийг сонгож батлах
5. ТУЗ-ийн төсөв батлах /цалин урамшууллын хэмжээг тогтоох/
6. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг батлах
7. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн шинэчилсэн журмуудыг батлах тухай

Хэлэлцсэн нь:

1-р асуудал:

Х. Золжаргал хурлын дарга бөгөөд ТУЗ-ийн дарга /хараат бус/

-Дархан нэхий ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ээс өгсөн дүгнэлтийг нэг бүрчлэн тайлбарлан танилцууллаа. Тэрээр Дархан Нэхий ХК нь 2022 оны нийт борлуулалтын нийт орлого 2021 онтой харьцуулахад 8 % аар буурч, бүтээгдэхүүний өртөг 5% аар буурч, ашиг 2%-аар өсч, 3.7 тэрбум төгрөгний цэвэр ашигтай ажилласан байна. Ажиллагсдын цалин, импортын түүхий эд, туслах материалын үнэ нэмэгдсэн, олон жил хадгалсан бараа, материалыг акталсан зэргээс гадна ашиглалтын зардал нь өмнөх жилийнхээс 1,2 тэрбумаар буюу 455% -аар өссөн нь үйлдвэрлэлийн салбарын ашиг буурахад нөлөөлсөн байна. Ашиглалтын зардлыг 2021 онд 3Г-аас чөлөөлж байсан нь дээрх зөрүү өндөр гарахад нөлөөлжээ.

Ашгийг компанийн салбаруудаар харвал Үйлдвэрлэлийн салбарын цэвэр ашиг 21 %-аар буурч, үйлчилгээний салбарынх 54%-аар өссөн байна. Үйлдвэрлэлийн салбарын ашиг буурахад өртөг, зах зээлийн худалдан авах чадвар, бүтээгдэхүүний нэр төрөл, чанар байдал, Ковидын дараах логистик, саатал, бүтээгдэхүүн хөгжүүлэлттэй холбоотой асуудлууд нөлөө үзүүлсэн байна. Үйлчилгээний салбарын орлого, ашиг өсөхөд Ковидын дараах үйлчилгээний салбарын өсөлт, хөрөнгө оруулалтын өгөөж, менежментийн багийн ур чадвар зохих нөлөө үзүүлсэн байна.

Чадварлаг боловсон хүчний олох, тогтоох, хүний хүчин зүйлийг бүрэн дүүрэн ашиглах, бүтээмж нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг шинэ түвшинд гаргах, өртөг бууруулах зэргийг анхаарах цаг болжээ. Экспортын зах зээл судлах, олох, бараа бүтээгдэхүүнээ олон улсын жишигт нийцүүлэх, валютын эх үүсвэр олох, зах зээлээ тэлэх асуудал бас их чухал байна.

2022 онд татвар, шимтгэлд нийт 2,8 тэрбум төгрөг төлж, ажиллагсдын дундаж цалин өмнөх оноосоо 43% өсч 1,5 сая төгрөгт хүрсэн байна.

Тайлант хугацаанд нийт 13 тэрбум төгрөгний зээл төлж барагдуулсан байна.

БНХАУ-ын зүгээс хилээ нээгээгүй, мэргэжилтнүүд ирж чадаагүйгээс голлон шалтгаалж шахмал ширний үйлдвэр ашиглалтанд орж чадсангүй.

2022 онд Дархан Нэхий компани байгуулагдсаны түүхт 50 жилийн ой болж, энэ ойг угтсан олон бүтээлч ажлуудыг компанийн болон ажиллагсдын өөрсдийн хүч, хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн, ой угтсан уралдааныг дүгнэсэн нь хамт олны уур амьсгалд эерэг нөлөө үзүүлсэн байна,

Дархан Нэхий ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2022 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц, бололцоогоо дайчлан ажилласан гэж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дүгнэж, Компанийн 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэн, дүгнэлтээ компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулах нь зүйтэй гэж тогтсоныг танилцууллаа.

2-р асуудал:

КтХ-ийн 96.4-д заасан ТУЗ-ийн тайланг хурлын дарга бөгөөд ТУЗ-ийн дарга, /хараат бус/ Х. Золжаргал танилцууллаа.

Үүнд:

- Дархан Нэхий ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлж ирлээ.

Монголын СЗХ-оос батлан гаргасан Хувьцаат компаниудад зориулсан Засаглалын өөрийн үнэлгээг энэ жил хийж гүйцэтгэлээ.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмуудыг шинээр боловсруулан баталлаа. МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудаас тухайн жилийн ХЭХ-аа 3-р сарын эхний хагаст зарлан хуралдуулж байгаа СЗХ-ны дүгнэлтэнд жишиг болон үнэлэгдлээ.

ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг толгой болон охин компани нэг бүрээр тайлан тавиулж, дүгнэж ажиллалаа.

ТУЗ нь 2022 онд нийт 4 ээлжит хурал болон 17 ээлжит бус хурал зохион байгуулж, гишүүдээс ирүүлсэн саналын олонхоор шийдвэр гаргаж ирлээ. Бүтэц зохион байгуулалттай холбоотой 3, хөрөнгө оруулалттай холбоотой 10, эзэлтэй холбоотой 3, актлах устгахтай холбоотой 3 тогтоол, бусад дотоод үйл ажиллагаатай холбоотой нийт 34 тогтоол баталсан байна.

Мөн дэргэдээ байнгын Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг ажиллуулж, СЗХ-ноос гаргасан зөвлөмжийн дагуу ТУЗ-ийн дарга, Хороодын дарга нараар ТУЗ-ийн хараат бус гишүүд ажилласан.

ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо нь Дархан Нэхий ХК-ийн гүйцэтгэх удирдлагын багийн 2021 оны ажлыг дүгнэж, нэр бүхий 3 компанийн гүйцэтгэх удирдлагын багт урамшуулал олгох шийдвэр ТУЗ-д оруулж шийдвэрлүүлээ. Эрх бүхий албан тушаалтнуудын онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний загвар боловсруулж, байгуулж, 1 охин компанийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтыг хийж, ТУЗ-ээр шийдвэр гаргуулсан байна.

Цалин урамшууллын хороо нь 2022 оны гүйцэтгэх удирдлагын багийн 2022 оны цалин урамшууллыг өнгөрсөн жилийн ажлын үзүүлэлтийг харгалзан шинэчлэн тогтоох, гэрээнд тусгуулахаар санал гарган, ТУЗ-ээр хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Компанийн нийт ажиллагсдын дундаж цалин, хөлсийн инфляцитай уялдуулан тогтоохоор санал гаргаж, ТУЗ-ээр шийдвэр гаргууллаа.

Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлан, санхүүгийн мэдээ, мэдээлэлд болоз ТУЗ-өөс гаргасан холбогдолтой тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа. Нэг охин компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит оруулж, холбогдох арга хэмжээг авахуулсан байна. Сонирхлын болон их хэмжээний гэрээ, хэлцэл энэ хугацаанд хийгдээгүй байна.

2022 оны ХЭХ-ийн хурлаас батлагдсан ТУЗ-ийн төсвийн гүйцэтгэл 86% тай буюу 14%-ийн хэмнэлттэй гарсан байна.

Тайланд хугацаанд хувьцаа компанийн эзэмшигчдийн тоо 4600 хүнээс 4900 орчим болон нэмэгдэж, хувьцааны ханш 15 орчим % буурсан нь ТОП-20 ангилалын индексийн бууралтай (шинээр ангилалд орж ирсэн банк, ББСБ-ын үнэлгээг эс тооцвол) ойролцоо байна.

Х. Золжаргал:

- ТУЗ-ийн тайлантай холбоотой санал байна уу? За санал, асуулт, тодруулах зүйл байхгүй бол дараагийн асуудлыг хэлэлцье.

3-р асуудал:

Х. Золжаргал Хурлын дарга

-Дархан нэхий ХК-ийн дүрмийн өөрчлөлтийг танилцууллаа. Тэрээр сайн засаглалыг би болгох үйл ажиллагааг сайжруулах, засаглалын кодексн талаархи СЗХ-ноос гаргасан журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн дүрэмд зайлшгүй өөрчлөлт хийгдэж байна. Энэхүү дүрмийн өөрчлөлт нь 30 хувьд хүрч байна. Иймд хэлэлцэж буй асуудлыг дүрмийн өөрчлөлтөөр батлах уу. Шинэчилсэн дүрмээр батлах уу. Та бүгд саналаа өгөөрэй. ТУЗ-д байнгын 3 хороо ажилладаг ба нэмж Стратеги төлөвлөлтийн хороо, Бизнес, гүйцэтгэлийн хяналтын хороо ажиллуулахаар болж байгаа. Үүнтэй холбогдон ТУЗ-ийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх санал оруулсан. Дүрэм нийтдээ 13 зүйлээс бүрдсэн байгаа гэж танилцууллаа.

Чанцал: хувьцаа эзэмшигч

-Үйл ажиллагаа хяналтын хорооны талаар тодруулъя.

Х. Золжаргал:

-Бизнесийн гүйцэтгэлийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэнэ. Энэ хороо ТУЗ-д байна.

Э. Батсайхан:

Хуучин манайд ГУМенежер Даваадулам гэж хүн захирлуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэдэг байсан. Үүний нэгэн адилаар явагдана. Одоо санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд холилдож орж ирж байна. Гүйцэтгэх захирлууд орлогын төлөвлөгөө, борлуулалтын төлөвлөгөө, ашгийн төлөвлөгөө, тээврийн төлөвлөгөө, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг анхаарч, эдгээрийн биелүүлж, хэрэгжүүлэхийг зорьж ажиллаж, хийж явах хэрэгтэй. Харин санхүү санхүүгийн бүртгэлийн ажлыг ялангуяа хөрөнгийн бүртгэлийг сайн хийх хэрэгтэй.

Орост татварын байцаагчид бизнесийнхэнтэй нүүр тулж харьцахгүйгээр зохицуулалт хийсэн байна. Иймээс ямарч татварын дарамт байхгүй байна. Захирлууд орлогын төлөө явахгүй байгаа нь санхүүгийн ачааллыг нэмэгдүүлж байна. Тайлангаа бид энэ чиглэлээр авах

Б. Чанцал:

Тайлангаа 2 газарт өгөх үү.

Э. Батсайхан:

Гүйцэтгэлийн удирдлагын буюу бизнес гүйцэтгэл хяналтын хороонд гүйцэтгэх захирлууд тайлангаа өгнө.

Хуралд оролцогчид ТУЗ 9 гишүүнтэй байхыг дэмжлээ. Дүрмийн өөрчлөлтийн асуудлаар хувьцаа эзэмшигчид хоорондоо хэсэг ярилцаад шинэчилсэн дүрэм хэлбэрээр бүртгүүлж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж санал нэгдлээ.

4-р асуудал:

Х. Золжаргал: Хурлын дарга

-ТУЗ-ийн гишүүнийг сонгож, батлах асуудлыг хэлэлцье. ТУЗ-д нийтдээ 14 иргэн нэр дэвшсэн бөгөөд үүнээс ТУЗ-ийн ердийн гишүүнд 6 иргэн, хараат бус гишүүнд 8 иргэн тус тус нэр дэвшсэн байна. Нэр дэвшигчдийн анкет, хараат бус гишүүний шалгуурыг хангасан эсэх талаархи мэдээллийг нэр дэвшигч тус бүрээр товч танилцууллаа. ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал өгөхдөө шинэчлэн баталсан санал хураах кумулятив арга хэрэглэх журам"-ын дагуу өгөхийг дахин санууллаа.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн 4 нь ердийн, 5 нь хараат бус гишүүн байна. Одоо дараагийн асуудалд орё.

5-р асуудал:

ТУЗ-ийн дарга Х. Золжаргал ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг танилцуулав.

Үүнд:

ТУЗ-ийн гишүүний цалин жигд 350.000₮, хорооны гишүүний нэмэгдэл 350.000₮, хорооны даргын нэмэгдэл 700.000₮, ТУЗ даргын нэмэгдэл 1.0 сая₮ болон ТУЗ н/б даргын нэмэгдэл 500.000₮. цалин нь 1,0 сая ₮ байна. Бусад ТУЗ-ын төсөв ТУЗ дээр батлагдана.

Д. Батжаргал: Хувьцаа эзэмшигч

ТУЗ-ийн гишүүдийг сайн ажиллуулахын тулд цалин урамшууллыг сайн өгч, ажлыг нь бодитоор дүгнэж байх нь чухал юм.

Х. Золжаргал:

ТУЗ-ийн гишүүний хувьд гүйцэтгэх удирдлага цалин авна гэж урамшууллыг тооцсон байгаа.

Б. Чанцал:

Батжаргалын саналтай санал нэг байна.

Д. Батжаргал:

ТУЗ-ийн гишүүд үр ашигтай, өгөөжтэй ажиллаж засаглалаа сайжруулах хэрэгтэй.

6-р асуудал:

Х. Нарантуяа: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

-Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 17-ны өдрийн 06 тоот тогтоолыг уншиж танилцуулаад, ногдол ашиг хуваарилах нь ТУЗ-ийн эрх мэдлийн асуудал боловч КТХ-д зааснаар ХЭХ-д заавал танилцуулна гэсний дагуу хэлэлцэх асуудалд оруулж танилцуулж байгааг тайлбарлав.

7-р асуудал:

Энэ хэлэлцэх асуудалтай танилцаад хуралд оролцогчид ТУЗ-ийн журам батлах асуудал нь ТУЗ-ийн эрх мэдлийн хүрээний асуудал тул ТУЗ-ийн гишүүд хурлаараа шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Х. Золжаргал хурлын дарга

-За хурлын асуудлуудыг хэлэлцэж дууссан бол саналын хуудсаа бөглөцгөөе.

Ингээд хурлаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууссан тул хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа өгч, тус бүрийн саналын хуудсыг тооллогын комисс хүлээн авч, дүгнэн эцсийн дүнг танилцуулж, Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01, 02, 03 шийдвэрийг тооллогын комиссын дарга Б. Орхончимэг уншиж танилцууллаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналын дүн:

1.Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайлантай танилцсаныг батлах, ТУЗ -ийн гишүүн сонгох асуудлыг батлах, ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг батлах, Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-аас гаргасан шийдвэртэй танилцсаныг батлах, ДНХК-ийн шинэчилсэн дүрмийг батлах, ТУЗ-ийн журмуудыг ТУЗ өөрийн эрх мэдлийн хүрээнд хэлэлцэж батлах шийдвэр гарсныг тус тус танилцуулав.

2.ТУЗ-ийн гишүүдийг сонгох саналын дүн:

Санал хураалтаар доорхи 9 гишүүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгож, үүнээс ердийн гишүүнд 4, хараат бус гишүүнд 5 гишүүн сонгогдсон тухай дүнг танилцуулав.

1.ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

1. Эрдэнэдалайн Батсайхан - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,0 хувийн саналаар;
2. Равжаагийн Сүмбэнхүү - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,0 хувийн саналаар;
3. Батсайханы Чинчулуун - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,0 хувийн саналаар;
4. Батсайханы Мягмар-Өлзий - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,0 хувийн саналаар;

2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

5. Далхжавын Батжаргал - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,0 хувийн саналаар;
6. Хумбагайн Золжаргал - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,0 хувийн саналаар;
7. Цоодолсүрэнгийн Хадаа - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,0 хувийн саналаар;
8. Янсангийн Ариунтөгс - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,0 хувийн саналаар;
9. Ганбаатарын Хос-Эрдэнэ- Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,0 хувийн саналаар;

тус тус сонгогдсон байна.

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 дүгээр сарын 04-ны өдрийн хуралдаанаас дараах шийдвэрийг гаргалаа.

Хурлын шийдвэр:

1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. КТХ-ийн 96,4-д заасан ТУЗ-ийн тайланг танилцуулсныг батлах
3. Дархан нэхий ХК-ийн шинэчилсэн дүрмийг батлах
4. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож, батлах
5. Дархан нэхий ХК-ийн 2023 оны ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, төсвийг батлах
6. "Ногдол ашиг хуваарилах тухай" ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 17-ний өдрийн 06 тоот тогтоолыг танилцуулсныг батлах
7. ДНХК-ийн ТУЗ-ийн шинэчилсэн журмуудыг ТУЗ өөрийн эрх мэдлийн хүрээнд хэлэлцэж батлахыг зөвшөөрөх

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТАНИЛЦСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ХУРЛЫН ДАРГА



Х.НАРАНТУЯА

Х. ЗОЛЖАРГАЛ